МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР САНГИЙН ЯАМ

# ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

## 1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

| **Гэрээний нэр** | **Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх** |
|---|---|
| Гэрээний дугаар | СЯ 1605 |
| Захиалагч байгууллага | Сангийн яам |
| Захиалагч байгууллагын төлөөлөх эрх бүхий нэгж | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар |
| Гүйцэтгэгч байгууллага | Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг |
| Гэрээгээр ажил эхлүүлсэн хугацаа | 2018 оны 12-р сарын 15 |
| Гэрээгээр ажил дуусах хугацаа | 2019 оны 12-р сарын 6 |

## 2. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

| **Гэрээний үүргийн нөхцөл** | **Хэрэгжилт** | **Биелэлт /хувиар/** |
|---|---|---|
| 3.1.1<br>ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөр, шалгалт авах журмыг тус тус батлуулан мөрдүүлж, шалгалтыг зохион байгуулах; | */ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №1/*<br>✓ Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартын сургалтын жишиг хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг боловсруулах ажлыг ММНБИ-тэй хамтран гүйцэтгэсэн.<br><br>*ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөр:*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №2/*<br>✓ Татварын багц хууль нь 2020.01.01-ээс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд 2019 оны 4-р улирал багтаан эцэслэхээр ажиллаж байна.<br><br>*ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт:*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №3/*<br>ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт нь 2019 оны байдлаар:<br>✓ Улаанбаатар хотод 10 удаа зохион байгуулж 296 нягтлан бодогчид хамрагдсанаас сургалтын журамд | *80%* |

| | |
|---|---|
| | заасны дагуу шаардлага хангасан 296 суралцагч батламж авсан.<br>✓ Орон нутагт Өмнөговь, Увс, Орхон, Хөвсгөл, Ховд, Дархан аймгуудад тус бүр нэг нэг удаа зохион байгуулагдаж нийт 115 нягтлан бодогч хамрагдаж, батламж авсан.<br><br>*<u>ТМЗ-ийн эрх сунгах сургалт:</u>*<br>✓ ТМЗ-ийн эрх анх сунгах сургалтыг танхимаар 3 удаа зохион байгуулж нийт 173 гишүүн хамрагдлаа.<br>✓ ТМЗ-ийн эрх дахин сунгах сургалтыг онлайнаар 7 удаа зохион байгуулж нийт 276 гишүүн хамрагдлаа.<br>*<u>ТМЗН-ээс зохион байгуулагдах сургалтыг цахимжуулах:</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №4/*<br>✓ ТМЗ-үүдэд цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломж олгох зорилгоор ТМЗ-ийн эрхийг дахин сунгаж буй гишүүдэд зориулсан сургалтыг 7 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж, 404 ТМЗ гишүүн;<br>✓ Татвар төлөгчдийн татвараа төлөх нийгмийн сэтгэлгээг дээшлүүлэх, татварын хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэх үүднээс тасралтгүй боловсролын цахим сургалтыг 10 удаа зохион байгуулж, 400 гаруй гишүүд, дэмжигчдийг, танхимын сургалтыг 10 удаа зохион байгуулж 190 орчим гишүүд дэмжигчид, нягтлан бодогчдыг тус тус хамруулсан байна.<br><br>*<u>ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын журам:</u>*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №5/*<br>✓ СЯ-ны НБББГ-тай хамтран "Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам"-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн зарим асуудлыг тодорхой болгох, сайжруулах зорилгоор шаардлагатай зохих засвар, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Шинэчилсэн "Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам" Сангийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 101 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан болно.<br><br>*<u>ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах шалгалтын бүрэлдэхүүнийг томилж, батлуулах:</u>*<br>*ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №6/*<br>✓ ТМЗҮТХ-ийн 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах шалгалтын бүрэлдэхүүн томилуулах саналыг СЯ-ны НБББГ-т | |

| | | | |
|---|---|---|---|
| | хүргүүлэн Сангийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 95 дугаар тушаалаар ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах шалгалтын бүрэлдэхүүн томилогдсон.<br><br>*ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт:*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №7/*<br>✓ 2019 оны эхний хагас жилийн байдлаар ТМЗ-д эрх олгох шалгалтад Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 306 нягтлан бодогч хамрагдсанаас 60 нягтлан бодогч, ТМЗ-ийн эрх сунгах шалгалтад 290 ТМЗ тус тус тэнцэж, Сангийн сайдын 07 дугаар сарын 03-ны өдрийн 162 тоот тушаалаар 60 нягтлан бодогчдод татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг 3 жилээр олгохоор, 290 ТМЗ-ийн эрхийг 3 жилээр сунгахаар тус тус шийдвэрлүүлсэн. | |
| 3.1.2<br>ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх; татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангаж, тэдгээрийн бүртгэл. мэдээллийн санг бүрдүүлэх | *ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдэд чанарын хяналт хийх журам боловсруулах;*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №9/*<br>✓ ТМЗҮ-ний ерөнхий стандартыг хэрэгжүүлэх аргачлалыг засварлан сайжруулах, олон улсын жишгийг судлан түүнд нийцүүлэх ажил хийгдэж байна. Уг ажлыг ЗҮМХ-ны гишүүн Б.Уянга хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд хорооны хурлаар аргачлалыг хэлэлцүүлж эцэслэн Удирдах зөвлөлийн хурлаар батлахаар ажиллаж байна.<br>*ТМЗҮ-г тусгай зөвшөөрөлгүй хэрэгжүүлж байгаа этгээдүүдэд хариуцлага тооцох ажлыг эхлүүлэн мэдэгдэх хуудас илгээх ажил;*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №10/*<br>✓ ТМЗН-ээс цахим мэдэгдлийн төслийг боловсруулж 2019 оны 11 сарын 20-ны адрийн 02/98 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн болно.<br>*СЯ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдэд хуулийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллах хяналт шалгалтыг 5 аж ахуйн нэгжид хийх*<br>*СЯ, ТЕГ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдэд хуулийн нөхцөл шаардлагыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар хяналт шалгалт хийх;*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №12*<br>✓ Сангийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 84 дүгээр тушаалаар ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Орон нутгийн 3, Улаанбаатар хотын 14 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Аж ахуйн үйл | 50% |

| | | |
|---|---|---|
| | ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар хяналт шалгалтыг хийж ажиллаа. Хяналт шалгалтаар ТМЗҮТХ-ийн 9-р зүйлийн 9.2, 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасан зөрчил голлон илэрсэн байна. Хяналт шалгалтын ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтээр ТМЗҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг зөрчсөн 1 компанид гаргасан зөрчлөө 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор арилгаж энэ талаар эргэж мэдэгдэх хугацаатай үүрэг даалгавар өгч, ТМЗҮТХ-ийн 10 дугаар зүйлд заасныг зөрчсөн, ханган ажиллаагүй, хангахгүй байгаа нь тогтоогдсон 6 компанийн ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж, "Ай Эф Эс аутсорсинг ТМЗ" ХХК, Эйч эл би Монголия Аудит" ХХК-иудад ТМЗҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т шаардлагыг тасралтгүй хангаж ажиллах үүрэг даалгавар өгчээ. Мөн "Хөдрөг цэцүүх ТМЗ" ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 135 тоот тушаалаар тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.<br>*СЯ-тай хамтран ТМЗҮ эрхлэж буй хуулийн этгээдүүдийн мэдээллийн санг цахимжуулах;*<br>*/ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №13/*<br>✓ ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 36 компани байна. Эдгээр компаниудын мэдээллийн санг цахимжуулж сангийн яаманд хүлээлгэн өгсөн болно. | |
| 3.1.3<br>Мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах саналыг Захиалагчид тавьж шийдвэрлүүлэх | *ТМЗ-ийн зөвлөхийн эрхийг түтгэлзүүлэх, хүчингүйд тооцох:*<br>✓ Сангийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 162 тоот тушаалаар ТМЗҮТХ болон ТМЗ-д эрх олгох, сунгах журамд заасан шаардлагыг хангаагүй болон нас барсан зэрэг шалтгаанаар 136 ТМЗ-ийн эрхийг хүчингүйд тооцуулж шийдвэрлүүсэн байна. | *50%* |
| 3.1.4<br>Гишүүдийн татварын хэмжээ, сургалт, шалгалтын болон бусад нэмэгдэл үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг Захиалагчтай тохиролцон тогтоож мөрдүүлэх | Өөрчлөлт ороогүй. | 100% |
| 3.1.5<br>Шалгалтын тестийн сан | *ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын тестийн санг бүрдүүлэх, цахимжуулах, нэмэгдүүлэх;* | *100%* |

| | | |
|---|---|---|
| бүрдүүлэх. татварын чиглэлийн олон улсын бичиг баримт орчуулах, тайлбарлах, зөвлөмж боловсруулах, судалгааны ажил хэрэгжүүлэх; | */ТМЗН-ийн гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө №8/*<br>ТМЗ-д эрх олгох, эрхийг сунгах шалгуурт хууль тогтоомжийн өөрчлөлт, СТОУС-ын шинэчлэлийг уялдуулан хичээл тус бүрээр 40 асуулт, 10-20 бодлого бэлтгэн тестийн санг баяжуулах зорилт тавин ажилласан. Сорил шалгалтын тестийн санг 300 тестээр,<br>• СТОУСХ хичээл - 46 асуулт, 22 бодлого<br>• Татварын бүртгэл - 42 асуулт, 20 бодлого<br>• Хууль эрх зүй -45 асуулт<br>• Татварын онол -40 асуулт<br>• Эрх сунгах анх -41 асуулт,10 бодлого<br>✓ Эрх сунгах дахин -42 асуулт, 10 бодлого тус тус нэмэгдүүлсэн байна.<br><br>*Судалгааны ажил хэрэгжүүлэх:*<br>✓ Санхүү, татвар, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хийх судалгааг дэмжиж, хөгжүүлэхийн зэрэгцээ эдгээр салбарт тулгамдаж буй асуудлыг судалж илрүүлэн, түүнээс гарах арга зам, шийдлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлан боловсруулж олон нийт, холбогдох эрх бүхий байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлэх зорилгоор ТМЗ-ийн эрхээ сунгуулах гишүүдээр бие даалт болон судалгааны ажил хийлгүүлж байна. Шаардлагад нийцсэн судалгааны ажлуудаас сонгон англи хэл дээр хөрвүүлэн олон улсын "Татвар ба Бизнес" сэтгүүлд хэвлүүлэн нийтийн хүртээл болгон ажиллаж байна. | |
| 3.1.6<br>Тус гэрээнд заасан төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхдээ татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох. сунгах сургалт, шалгалтыг төлбөртэй зохион байгуулж болох бөгөөд 1 цагийн сургалтын төлбөрийн дээд хязгаарыг 3500 /гурван мянга таван зуун/ төгрөг; 1 цагийн шалгалтын төлбөрийн дээд хязгаарыг 8000 /найман мянга/ төгрөг байхаар тооцох | Өөрчлөлт ороогүй. | 100% |

| | | |
|---|---|---|
| 3.1.7<br>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн "Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай" 199 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэн, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагч болон холбогдох байгууллагад нь ирүүлж байх | МУ-ын ТМЗ-ийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэд, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг Захиалагчид хүргүүлж ажилласан. | 100% |
| 3.1.8<br>Нийгэмлэг өөрийгөө санхүүжүүлэх зарчмын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд иргэний хувьд төлөх татварын дээд хэмжээ 120000 /нэг зуун хорин мянга/ төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн элсэлтийн хураамж нь 2000000 /хоёр сая/ төгрөгөөс; Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөх татварын дээд хэмжээ нь татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний орлогын 0,5 хувиас тус тус хэтрэхгүй байх | Өөрчлөлт ороогүй. | 100% |
| 3.1.9<br>Гэрээ гүйцэтгэгч нь гэрээний 3.1.6, 3.1.8-д зааснаас бусад аливаа төлбөр хураамж татвар зэргийг гишүүд болон | Өөрчлөлт ороогүй. | 100% |

| | | |
|---|---|---|
| хуулийн этгээдээс авахгүй байх | | |
| | **Дундаж хувь** | **87%** |

## *2.2 СЯ-1605 тоот гэрээний хавсралтын биелэлт*

### Хавсралт А-Үйлчилгээний тодорхойлолт ба хуваарь

ТМЗН нь ТМЗҮТХ-ийн 18 дугаар зүйлийг үндэслэн энэхүү гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн болно. Үүнд:

**А-1 Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтын хэрэгжилт**

*Үйлчилгээ 1- Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт*

Сургалтын 70 дээш хувьд хамрагдсан нягтлан бодогчдод батламж олгож, шалгалт өгөх эрхийг нээж өгсөн. Сургалтын ирцийг хянаснаар суралцагчдын идэвхи, чанар сайжирсан санал асуулгыг дүнгээс харагдаж байна. Санал асуулга хуудасны загвар */Хавсралт-8 харуулав/*

*Үйлчилгээ 2- Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт*

ТМЗ болон татвар төлөгч иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан сэдвүүдээр тасралтгүй боловсрол олгох сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахын зэрэгцээ татварын хууль тогтоомжийн шинэчлэл өөрчлөлт, тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх, ТМЗ-ийн эрхийн хугацааг сунгуулах гишүүдээр судалгааны ажил хийлгэж, хамгаалуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Эдгээр ажлын үр дүнд татварын мэргэшсэн зөвлөхүүдийн оролцоо идэвхи сайжирч, чанар, чадвар нэмэгдэж байна.

- ТМЗ-үүдэд цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломж олгох зорилгоор ТМЗ-ийн эрхийг дахин сунгаж буй гишүүдэд зориулсан сургалтыг 7 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж, 404 ТМЗ гишүүн;
- Татвар төлөгчдийн татвараа төлөх нийгмийн сэтгэлгээг дээшлүүлэх, татварын хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэх үүднээс тасралтгүй боловсролын цахим сургалтыг 10 удаа зохион байгуулж, 400 гаруй гишүүд, дэмжигчдийг, танхимын сургалтыг 10 удаа зохион байгуулж 190 орчим гишүүд дэмжигчид, нягтлан бодогчдыг тус тус хамруулсан байна.

*Үйлчилгээ 3- Татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвөлгөө мэдээллээр хангах*

ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн удирдах ажилтны зөвөлгөөнийг тогтмол зохион байгуулж, дагаж мөрдөх ерөнхий стандартыг боловсруулан гаргасан. Стандартын хэрэгжилттэй холбоотой санал хүсэлтийг Зөвлөх үйлчилгээний менежментийн хороо хүлээн авч сайжруулан ажиллаж байна.

*Үйлчилгээ 4- Шалгалтад зориулж хичээл тус бүрээр иж бүрэн тестийн сан бүрдүүлэх*

Сургалт судалгааны менежментийн хороо нь тестийн санг шинэчилэн баяжуулах зорилгоор ТМЗН-д хичээл заадаг багш нараас хичээлийн чиглэл тус бүрээр тест авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

**А-2 Үйл ажиллагааны хуваарийн хэрэгжилт /2019/**

ТМЗН нь энэхүү гэрээнд заасан хуваарийн дагуу үйл ажиллагаагаа гүйцэтгэсэн болно. Үүнд:

| Үйл ажиллагаа | Хэрэгжилт |
|---|---|
| Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартын сургалтын жишиг хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх хөтөлбөр боловсруулахад ММНБИ-тэй хамтран ажиллах | Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартын сургалтын жишиг хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг боловсруулах ажлыг ММНБИ-тэй хамтран гүйцэтгэсэн. |
| ТМЗ-д эрх олгоход бэлтгэх, эрхийг сунгах сургалтын хөтөлбөрийг шинэчилэн боловсруулж, батлуулах | Татварын багц хууль нь 2020.01.01-ээс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор ТМЗ-д эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд 2019 оны 4-р улиралд багтаан эцэслэхээр ажиллаж байна. |
| ТМЗ-д эрх олгоход бэлтгэх, эрхийг сунгах сургалтын хуваарийг жилээр гаргаж, сургалтыг зохион байгуулах. Үүнд:<br>• Эрх олгох сургалтыг 5 удаа танхимаар<br>• Эрхийг анх сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 100 ТМЗ гишүүдийг хамруулсан байх<br>• Эрхийг дахин сунгах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 120 ТМЗ гишүүдийг хамруулсан байх | ТМЗ-д эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтыг:<br>• Улаанбаатар хотод 10 удаа зохион байгуулж 296 нягтлан бодогчид хамрагдсанаас сургалтын журамд заасны дагуу шаардлага хангасан 296 суралцагч батламж авсан.<br>• Орон нутагт Өмнөговь, Увс, Орхон, Хөвсгөл, Ховд, Дархан аймгуудад тус бүр нэг нэг удаа зохион байгуулагдаж нийт 115 нягтлан бодогч хамрагдаж, батламж авсан.<br>• ТМЗ-ийн эрх сунгах сургалт:<br>• ТМЗ-ийн эрх анх сунгах сургалтыг танхимаар 3 удаа зохион байгуулж нийт 173 гишүүн хамрагдлаа.<br>• ТМЗ-ийн эрх дахин сунгах сургалтыг онлайнаар 7 удаа зохион байгуулж нийт 404 гишүүн хамрагдлаа. |
| ТМЗН-ээс зохион байгуулагдах сургалтыг цахимжуулах. Үүнд:<br>• Эрхийг дахин сунгах сургалтыг 1 | ТМЗ-үүдэд цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломж олгох зорилгоор ТМЗ-ийн эрхийг дахин сунгаж |

| | |
|---|---|
| удаа цахимаар зохион байгуулах<br>• Тасралтгүй боловсролын /модуль/ сургалтыг 4 удаа цахимаар зохион байгуулах | буй гишүүдэд эрх сунгах сургалтыг 7 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж, 404 ТМЗ гишүүн;<br><br>Татвар төлөгчдийн татвараа төлөх нийгмийн сэтгэлгээг дээшлүүлэх, татварын хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэх үүднээс тасралтгүй боловсролын цахим сургалтыг 10 удаа зохион байгуулж, 400 гаруй гишүүдийг тус тус хамруулсан байна. |
| ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын журмыг шинэчлэн батлуулах | СЯ-ны НБББГ-тай хамтран "Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам"-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн зарим асуудлыг тодорхой болгох, сайжруулах зорилгоор шаардлагатай зохих засвар, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Шинэчилсэн "Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам" Сангийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 101 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан болно. |
| ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах, шалгалтын бүрэлдэхүүнийг томилж, батлуулах | ТМЗҮТХ-ийн 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийг ханган ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах шалгалтын бүрэлдэхүүн томилуулах саналыг СЯ-ны НБББГ-т хүргүүлэн Сангийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 95 дугаар тушаалаар ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах шалгалтын бүрэлдэхүүн томилогдсон байна. |
| ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт зохион байгуулах | 2019 оны эхний хагас жилийн байдлаар ТМЗ-д эрх олгох шалгалтад Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 306 нягтлан бодогч хамрагдсанаас 60 нягтлан бодогч, ТМЗ-ийн эрх сунгах шалгалтад 290 ТМЗ тус тус тэнцэж, Сангийн сайдын 07 дугаар сарын 03-ны өдрийн 162 тоот тушаалаар 60 нягтлан бодогчдод татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг 3 жилээр олгохоор, 290 ТМЗ-ийн эрхийг 3 жилээр сунгахаар тус тус шийдвэрлүүлсэн. |

| | |
|---|---|
| | 2019 оны 2-р хагас жилийн ТМЗ-д эрх олгох шалгалтыг 12 дугаар сарын 19-21-нд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. |
| ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын тестийн санг цахимжуулан, шалгалт зохион байгуулагдах бүрт хичээл тус бүрээр нэмэгдүүлэх. Үүнд:<br>• СТОУСХ хичээл - 40 асуулт, 20 бодлого<br>• Татварын бүртгэл - 40 асуулт, 20 бодлого<br>• Хууль эрх зүй -40 асуулт<br>• Татварын онол -40 асуулт<br>• Эрх сунгах анх -40 асуулт,10 бодлого<br>• Эрх сунгах дахин -40 асуулт, 10 бодлого | Сорил шалгалтын тестийн санг 300 тестээр,<br>• СТОУСХ хичээл - 46 асуулт, 22 бодлого<br>• Татварын бүртгэл - 42 асуулт, 20 бодлого<br>• Хууль эрх зүй -45 асуулт<br>• Татварын онол -40 асуулт<br>• Эрх сунгах анх -41 асуулт,10 бодлого<br>Эрх сунгах дахин -42 асуулт, 10 бодлого тус тус нэмэгдүүлсэн байна. |
| ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд чанарын хяналт хийх журмын төслийг боловсруулах | ТМЗҮ-ний ерөнхий стандартыг хэрэгжүүлэх аргачлалыг засварлан сайжруулах, олон улсын жишгийг судлан түүнд нийцүүлэх ажил хийгдэж байна. Уг ажлыг ЗҮМХ-ны гишүүн Б.Уянга хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд хорооны хурлаар аргачлалыг хэлэлцүүлж эцэслэн Удирдах зөвлөлийн хурлаар батлахаар ажиллаж байна. |
| ТМЗҮ-г тусгай зөвшөөрөлгүй хэрэгжүүлж байгаа этгээдэд хариуцлага тооцох ажлыг эхлүүлэн мэдэгдэх хуудас илгээх | ТМЗН-ээс цахим мэдэгдлийн төслийг боловсруулж Гүйцэтгэх захирлын 11 сарын 20-ны 02/98 тоот албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн болно. |
| СЯ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй 5 хүртэлхи хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авч, хариуцлага тооцох | Энэ ажил хийгдээгүй байна. |
| СЯ, ТЕГ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 16 хуулийн этгээдэд хуулийн | Сангийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 84 дүгээр тушаалаар ТМЗҮ эрхлэх |

| | |
|---|---|
| нөхцөл шаардлагыг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар хяналт шалгалт хийх | тусгай зөвшөөрөлтэй Орон нутгийн 3, Улаанбаатар хотын 14 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар хяналт шалгалтыг хийж ажиллаа. Хяналт шалгалтаар ТМЗҮТХ-ийн 9-р зүйлийн 9.2, 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасан зөрчил голлон илэрсэн байна.<br><br>Хяналт шалгалтын ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтээр ТМЗҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг зөрчсөн 1 компанид гаргасан зөрчлөө 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор арилгаж энэ талаар эргэж мэдэгдэх хугацаатай үүрэг даалгавар өгч, ТМЗҮТХ-ийн 10 дугаар зүйлд заасныг зөрчсөн, ханган ажиллаагүй, хангахгүй байгаа нь тогтоогдсон 6 компанийн ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж, “Ай Эф Эс аутсорсинг ТМЗ” ХХК, Эйч эл би Монголия Аудит” ХХК-иудад ТМЗҮТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т шаардлагыг тасралтгүй хангаж ажиллах үүрэг даалгавар өгчээ. Мөн “Хөдрөг цэцүүх ТМЗ” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Сангийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 135 тоот тушаалаар тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. |
| СЯ-тай хамтран ТМЗҮ эрхлэж буй хуулийн этгээдийн цахим мэдээллийн санг бий болгох | ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 38 компани байна. Эдгээр компаниудын мэдээллийн санг цахимжуулж сангийн яаманд хүлээлгэн өгсөн болно. |
| СЯ, ТМЗН хамтран ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд ТМЗҮ чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулах | • “ТМЗН-ийн удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 5 дугаар сарын 3-нд Улаанбаатар зочид буудалд “Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ Монголд” сэдвийн хүрээнд зохион байгуулаа. Уг зөвлөгөөнд ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдийн төлөөлөл, ТМЗ-үүд зэрэг 100 орчим хүн хамрагдлаа. |

| | |
|---|---|
| | • "ТМЗ-2019" чуулганыг 12 дугаар сарын 26-нд Блюскай зочид буудалд "Татварын хуулийн шинэчлэл ба зөвлөх үйлчилгээ" сэдвийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. |

## Хавсралт Б-Тайлагнах үүрэг хариуцлага

ТМЗН-ийн 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 02/132 тоот албан бичгээр үйл ажиллагааны тайланг /урьдчилсан байдлаар/ дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталсан жилийн эцсийн санхүүгийн тайланг, үйл ажиллагааны тайлангийн хамт 2019 оны 2 сарын 14-ны өдрийн 01/08 тоот албан бичгээр Захиалагч талд хүргүүлж ажилласан.

## Хавсралт В-Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчин

В-1 Үндсэн орон тооны ажилтан

| *Албан тушаал* | *Нэр* | *Тавигдах шаардлага* | *Чухал шаардлага, ур чадварын хангасан байдал* |
|---|---|---|---|
| Ерөнхийлөгч | Г.Алтанзаяа | Дээд боловсролтой, Доктор, профессор | ТМЗН-ийн үүсгэн байгуулагч, 2004 оноос хойш нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Татварын бүртгэл, нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн чиглэлээр 22 ном гаргаж, 22 илтгэл, 20 өгүүлэл хэлэлцүүлж, 8 төсөл, судалгааны ажил хийсэн байна. МУ-ын ТМЗ, МНБ |
| Гүйцэтгэх захирал | Ц.Болормаа | Дээд боловсролтой | 2005 оноос хойш ТМЗН-т сургалтын менежер, ажлын албаны дарга, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. |
| Ажлын албаны дарга/ Тамгын газрын дарга | Г.Хишигзул | Дээд боловсролтой | 2010 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэлийн багш, тамгын газрын даргаар ажиллаж байна. Магистр зэрэгтэй. |
| Сургалтын менежер | О.Батсүх | Дээд боловсролтой | 2018 оны 12 сараас хойш сургалтын менежерээр ажиллаж байна. |
| Нягтлан бодогч | П.Дашдаваа | Дээд боловсролтой, магистр | 2019 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогчоор ажиллаж байна. Магистр зэрэгтэй. МУ-ын ТМЗ, Хуульч |

| | | | |
|---|---|---|---|
| | | зэрэгтэй | мэргэжилтэй. |
| Мэдээлэл технологын инженер | Ү.Ганболд | Дээд боловсролтой | 2016 оноос хойш ТМЗН-т мэдээлэл технологын инженерээр ажиллаж байна. |
| Гишүүд, орон нутгийн салбар хариуцсан менежер | Ц.Хажидмаа | Дээд боловсролтой | 2006 оноос хойш ТМЗН-т Гишүүд, орон нутаг хариуцсан менежерээр ажиллаж байна. |
| Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан менежер | Э.Тайвансайхан | Дээд боловсролтой, англи хэлний өндөр мэдлэгтэй | 2018 оноос хойш ТМЗН-т Судалгааны төв, гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан менежерээр ажиллаж байна. Магистр зэрэгтэй. |
| Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах менежер | Г.Цэрэндулам | Дээд боловсролтой, Сэтгүүлч мэргэжилтэй | 2018 оноос хойш ТМЗН-т ажиллаж байна. |
| Туслах ажилтан | Ш.Даваажаргал | Дээд боловсролтой, | 2017 оноос хойш ТМЗН-т туслах ажилтан, няраваар ажиллаж байна |

В-2 Орон тооны бус бүрэлдэхүүн

| *Албан тушаал* | *Тавигдах шаардлага хангасан байдал* |
|---|---|
| Удирдах зөвлөл | ТМЗН-ийнбүх гишүүдийн ээлжит IV их хурлаар /2017 оны 5 дугаар сарын 12 өдрийн/ удирдах ажлын туршлага, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий ТМЗ гишүүд удирдах зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 11 гишүүн сонгогдсон болно. |
| Хяналтын зөвлөл | ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит IV их хурлаар удирдан зохион байгуулах туршлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий татварын мэргэшсэн зөвлөх гишүүд хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 5 гишүүн сонгогдсон болно. |
| Менежментийн хороод | ТМЗН-ийн УЗ-ийн 2017 оны 9 дугаар сарын 27 өдрийн хуралдаанаар удирдан зохион байгуулах туршлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий татварын мэргэшсэн зөвлөх |

| | |
|---|---|
| | гишүүдийг менежментийн хороонд ажиллуулахаар томилсон болно. |

## Хавсралт Г-Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл

| *Үйлчилгээ* | *Үйлчилгээний төрөл* | *Техник хэрэгсэл* |
|---|---|---|
| Үйлчилгээ 1 | Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалт | • *Сургалтын анги танхим*: 40 суралцагчийн багтаамжтай, ухаалаг самбар, проектор, комьпютер зэрэг иж бүрэн хэрэгсэлээр тоноглодсон.<br>• *Сурах бичиг гарын авлага:* Сургалтын батлагдсан хөтөлбөрийг агуулсан ном сурах бичиг, гарын авлагын бэлтгэн, тухай бүр шинэчлэн суралцагчдад өгдөг.*/Хавсралт-5/*<br>• *Багшлах боловсон хүчин:*Хичээл тус бүрт тухайн чиглэлээр ажиласан туршлагатай нарийн мэргэшсэн мэргэжилтэн, их дээд сургуулиудын багш, татварын мэргэшсэн зөвлөх нартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг. |
| Үйлчилгээ 2 | Татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийг сунгах тасралтгүй боловсролын сургалт | |
| Үйлчилгээ 3 | Татварын мэргэшсэн зөвлөхийн хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө мэдээллээр хангах | |
| Үйлчилгээ 4 | Шалгалтад зориулж хичээл тус бүрээр иж бүрэн тестийн сан бүрдүүлэх | |

| **Гэрээний хэрэгжилтийг шалгах явцад гарсан санал** | | |
|---|---|---|
| Сангийн яам | 1. Сургалтын хөтөлбөрийг Олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж батлуулах<br>2. Гишүүдийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих журмыг боловсруулж мөрдүүлэх<br>3. Чанарын хяналтын журмыг боловсруулах | |
| ТМЗН | 1. ТМЗҮ-ний тухай хуулийн биелэлтийг сайжруулах<br>2. Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ 11.20 дугаар зүйлийн 2-т *Хуульд заасан эрх, тусгай зөвшөөрөл авахгүйгээр зөвлөх үйлчилгээ эрхэлсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Хэрэгжилтэнд хяналт тавих* | |

### 3. ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

Гүйцэтгэгч болох Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг нь гэрээний үүргээ дундажаар 87%/наян долоо/ хувь биелүүлсэн гэж дүгнэв.

**Захиалагчийг төлөөлж:**

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД:
Ч.ХҮРЭЛБААТАР

---

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА:
Ч.ЧИМИДСҮРЭН

---

САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:
Б.БОЛОРМАА

---

**Гүйцэтгэгчийг төлөөлж:**

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:
Ц.БОЛОРМАА

---

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:
Г. ХИШИГЗУЛ

---